

БАТЛАВ.
БОЛОВСРОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД
СОНХАМГАЛАН

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2022 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

Дээд боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагаанд хичээл сургалтын үйл ажиллагааг танхимын болон танхимын бус /цахим хэлбэр/ хосолсон хэлбэрээр чанартай, тэгш, хүртээмжтэй зохион байгуулж, сургалт, судалгаанд ашиглах цахим эх сурвалжийг ашиглах сан бүрдүүлж, багш нарын нийгмийн баталгааг дээшлүүлж, сургалт, судалгааны ажлын чанарыг сайжруулах зорилгыг дэвшүүлж байна.

Энэхүү зорилгыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

Нэг. Дээд боловсролын эрх зүйн орчин

- 1.1. 2021 оны шинэчилсэн Дээд боловсролын тухай хуульд нийцүүлж их, дээд сургуулийн дотоод харилцааг зохицуулсан дүрэм, журмын шинэчлэлт хийнэ.
- 1.2. Дээд боловсролын газрын харьяа байгууллагын дотоод харилцааг зохицуулсан дүрэм, журмын шинэчлэлт хийнэ.

Хоёр. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт

- 2.1. Үндэсний тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрийг дэмжиж, хөтөлбөрийн давхцалыг арилгана.
- 2.2. Сургалтын байгууллагын тэнхим, профессорын баг, нэгж бүрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог сайжруулж, хөндлөнгийн үнэлгээ хийнэ.
- 2.3. Үндэсний мэргэшлийн хүрээг боловсруулж, өмнөх сургалтыг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэлт хийх системийг бий болгоно.
- 2.4. Тэнхимийн бус сургалт, судалгаанд ашиглах цахим эх сурвалжийг нэмэгдүүлнэ.
- 2.5. Ерөнхий суурь хичээлийн нээлттэй онлайн жишиг хичээлийг боловсруулж, сургалтад нэвтрүүлнэ.
- 2.6. Өрсөлдөх чадвар бүхий судалгаа шинжилгээний дэд бүтцийг үе шаттай бүрдүүлнэ.
- 2.7. Ахисан тувшний англи хэл дээрх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх
- 2.8. Цахим номын сангийн үйлчилгээг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх

Гурав. Багш, оюутны нийгмийн баталгаа

- 3.1. Чадварлаг багш, эрдэмтэн, судлаачдыг дэмжиж, чадавхжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.2. Эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх олон улсын мэдээллийн сүлжээнд холбогдоно.
- 3.3. Ахисан түвшний сургалт, судалгаа инновацын ажлын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.4. Их, дээд сургуулийн багш наарт зориулсан эмнэлгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.5. Оюутанд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хичээлийн байр, лаборатори, номын сангаар үйлчлүүлнэ.
- 3.6. Өмчийн хэлбэрийг үл харгалзан их, дээд сургуульд суралцагчдын тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээлийн сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулна.
- 3.7. Төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын байранд зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Орон нутгийн их, дээд сургуулийг дэмжих

- 4.1. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгийн дээд боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2. Орон нутгийн их, дээд сургуульд суралцагчдын авьяас, суралцахуйг дэмжсэн тэтгэлэг, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

---оОо---